


**“УСНЫ ТАЛААРХИ ИРГЭДИЙН
МЭДЛЭГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ
СУДАЛГАА” (2013)- НЫ ГОЛ ҮР ДҮН**

**Өмнөговь аймаг
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ЗОРИУЛСАН ЭМХЭТГЭЛ
2015 оны 9 дүгээр сар**



Санхүүжүүлэгч байгууллагууд:

Агуулга

Танилцуулга	1
Ундны усны чанар	3
Усны менежмент	9
Усны хүртээмж	13
Усны төлөөх өрсөлдөөн	20
Усны талаархи мэдээллийн эх үүсвэр	23
Ирээдүй	27
Эх сурвалж	29

Танилцуулга

Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) нь говийн бүс нутагт аж төрж буй малчид, уул уурхайн компаниуд, орон нутгийн удирдлагууд зэрэг олон талын усны талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлж, улмаар харилцан ойлголцлыг сайжруулж, усны асуудлаар хамтарч шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлэх зорилготой тодорхой ажлуудыг хийж байна.

Энэ зорилгын дагуу, ОУСК-ийн захиалгаар “Хараат бус судалгааны хүрээлэн” ТББ 2013 онд Өмнөговь аймагт дараах гурван асуудлаар олон нийтийн дунд судалгаа явуулсан. Үүнд:

1. Усны хүртээмж
2. Усны хэрэглээ
3. Өрхийн хэрэгцээний усны чанар ба хүртээмж (өнгөрсөн, одоо, ирээдүй)

Судалгааны гол үр дүнгээс тоймловол:

1.

Малчдад мэдээлэл дутмаг байна. Жишээ нь: Усны хүртээмжийн талаар.

3.

Компаниудаас өгсөн мэдээлэлд малчид ерөнхийдөө үл итгэх хандлагатай. Жишээ нь: Уул уурхайн үйл ажиллагаанаас усанд үзүүлэх нөлөөллийн талаар.

2.

Тодорхой баримтад үндэслээгүй зарим үзэл бодлууд Жишээ нь: Ундны усны чанарыг шалгах ахуйн нөхцөлд ашиглаж болох энгийн арга байхгүй.

4.

Малчдын санааг зовоосон асуудлууд багагүй байна. Жишээ нь: Уурхайд ус ихээр ашигладаг тул яваандаа бэлчээрт сөргөөр нөлөөлнө гэсэн санаа бодол түгээмэл байна.

Түүнчлэн :

Энэ талаархи мэдээлэл авдаг дөрөв дэх түгээмэл эх үүсвэр нь ам дамжсан яриа болдог гэж судалгаагаар гарсан.



усны талаар ямар нэгэн мэдээлэл солилцож, авч байгаагүй



усны талаар мэдээллээр дутмаг



мэдээлэл илүү авахыг хүсдэг байна

Үүний үр дүнд ОУСК усны менежментийн практик туршлага, оролцоог сайжруулж, чадавхийг бэхжүүлэхэд нь уул уурхайн салбарт дэмжлэг үзүүлж байгаа юм.

Энэхүү эмхэтгэл нь ОУСК-ийн захиалгаар Хараат бус судалгааны хүрээлэнгээс 2015 онд Өмнөговь аймагт явуулсан цуврал хэлэлцүүлэгт зориулж бэлтгэсэн мэдээлэл юм. Үүнд 2013 оны судалгааны үр дүнгээс гадна “Sustainability East Asia” (Састэйнэбилити Ийст Азиа) болон “Groundwater Solutions” (Граундуотер Солушнс) байгууллагуудын 2014 онд зохион байгуулсан (ОУСК-ийн дэмжлэгтэй) усны талаарх сургалтын зарим мэдээллийг орууллаа.

ОУСК-ийн дэмжлэгтэйгээр “Усны хяналт шинжилгээ” сургалт болон бусад ажлууд говийн бүсэд 2015-2016 онд хийгдэхээр хүлээгдэж байна.


Тэмдэглэл. Эмхэтгэлд орсон ихэнх мэдээлэл нь 2013 оны судалгааны үр дүнг хялбаршуулсан хувилбар юм. Судалгааны асуултад хариулт өгсөн оролцогчдын “дундаж” тоог төвөггүй гаргах боломжтой ч “нээлттэй асуулт”-д өгсөн хариултын дундаж тоог гаргах тийм ч хялбар биш. Тиймээс оролцогчдын өгсөн бүрэн хариултуудыг дэлгэрэнгүй (судалгааны арга зүй, мэдээллийн дүн шинжилгээ) мэдэхийг хүсвэл судалгааны эцсийн тайлантай (IRIM, 2013) танилцах нь зүйтэй юм.

Ундны усны чанар

Ерөнхий үр дүн

2013 он

ӨМНӨГОВЬ АЙМАГ



Усны гол эх үүсвэр нь



худаг



усан сан



40%

“хамгаалттай”
худгаас усаа
авдаг



Өрх айл

87%



усыг
ундандаа
хэрэглэж
байна

(Эх сурвалж: www.mongoliaminingjournal.com)

УЛААНБААТАР



орон сууцны нэг оршин суугч



усыг
хэрэглэж
байна



гэр хорооллын нэг оршин суугч



усыг
хэрэглэж
байна

(Эх сурвалж: www.mongoliaminingjournal.com)





“Хамгаалттай” худаг - Тагтай, хайс хашаагаар хүрээлэгдсэн,
шувуу амьтны ялгадас орохоос хамгаалагдсан.

Иргэд усны чанарт хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлсийг дараах байдлаар дурджээ.



Ундны усны чанарыг тодорхойлогч зүйлс



Ундны усны чанарыг шалгахдаа дийлэнх (61%) нь “амг” болон “өнгө”-өөр нь ялгагдаг аж.


Ундны усны чанарт хамгийн ихээр нөлөөлсөн гурван хүчин зүйлс** (2013 оны судалгааны үр дүн)




Эдгээр хүчин зүйлс нь ундны болон ахуйн хэрэгцээний усны хүртээмжид дээрх дарааллын дагуу нөлөөлсөн гэж иргэд үзжээ.

Дүн шинжилгээ, санал зөвлөмж

Өмнөговь аймгийн иргэд одоогийн ундны усны чанарыг “Дунд зэрэг” хэмээн үзэж байна. Иргэдийн



өнгөрсөн хугацаанд гарсан өөрчлөлтийн талаар




цаашдын хандлагын талаар хариулт өгөхөд бэлэн биш байв.

Харин хариулт өгсөн иргэдийн санал “Өөрчлөлт гараагүй” гэсэн ч,



усны чанар муудсан



цаашид дордоно гэж бодож байна

Эндээс харахад иргэд өөрчлөлтийн талаар (өнгөрсөн ба ирээдүй) үзэл бодлоо илэрхийлэх нь бага бөгөөд эдгээр өөрчлөлт, ялангуяа ирээдүйн талаар илүү сөрөг хандлагагай байна.

Иргэд усны чанарыг ихэвчлэн амт ба өнгөөр нь (эсвэл ямар ч шалгуургүй) тогтоодог тул усны чанарын талаарх үзэл бодол нь яг нарийн зөв эсэх нь тодорхойгүй юм. Ялангуяа, шинжлэх ухааны үүднээс ундны усны чанарыг зөвхөн өнгөөр хэмжих нь тийм ч найдвартай арга биш юм. Усны өнгөнд нөлөөлдөггүй бохирдуулагчийн жишээ олон бийг санах хэрэгтэй.



Усны бохирдлыг шинжилжэ байгаа нь

Ундны усны чанарыг ихэвчлэн лабораторид шинжилдэг ба ихэнх оронд ус түгээх, шинжлэх ажлыг төрийн байгууллага голлон хариуцдаг ажээ.

Төвлөрсөн шугам сүлжээнээс ундны усаа авдаггүй газрын хувьд баталгаатай ундны ус олж авахад анхаарах зарим зүйлс бий. Жишээ нь, ундны усны хамгийн найдвартай эх үүсвэр нь:

- савласан ус,
- зөвшөөрөлтэй усан сан
- хамгаалалттай худаг юм.

Усан сан, худгийн усны чанарыг Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (МХЕГ) шалгах үүрэгтэй. Хэдий найдвартай эх үүсвэрээс (савласан ус авахаас бусад тохиолдолд) ундны усаа авч байгаа ч усаа зөөх, хадгалахдаа хүнсний зориулалтын сав ашиглах нь зүйтэй юм.

Бид хоол хийхдээ усаа буцалгаж хэрэглэдэг. Энэ нь ундны усанд агуулагдаж буй ихэнх бохирдлыг арилгаж, чанарыг нь дээшлүүлэх нэг арга юм. Гэсэн хэдий ч хоолонд хэрэглэх усаа найдвартай эх үүсвэрээс авах нь ялгаагүй чухал юм.

Гар ажиллагаатай жижиг метр болон багаж ашиглан (урвалж болон өнгө нь хувирдаг тууз бүхий) усыг шинжилж болно. Гэвч ихэнх нь зөвхөн цөөн хэдэн химийн бодисыг (хүчил, шүлт, давс) илрүүлэх чадалтай байдаг ба микробиологийн шинжилгээ хийх боломжгүй байдаг.

Дээр дурдсанаар хүмүүс ундны усны чанарыг өнгө, амт зэрэг тийм ч найдвартай бус аргаар хэмждэг байна. Үүнтэй адил усыг бохирдуулагч бодисыг танихдаа ч мөн эдгээр аргад найддаг. Усны чанар муудахад цаг агаар, улирлын хүчин зүйл ихээр нөлөөлж байна гэж иргэдийн дийлэнх нь зөв үнэлсэн ч ямар хүчин зүйл хэр хэмжээтэй нөлөөлж байгааг лабораторийн шинжилгээгээр тогтоох (Өмнөговь аймгийн хувьд нөхцөл ямар байгааг) шаардлагатай.



Усны менежмент

Үзэл бодол

Судалгаанд оролцсон ихэнх хүмүүс усыг зүй зохистой ашиглаж хамгаалахад орон нутгийн удирдлага, хөрш айл, яам агентлаг болон хувийн хэвшлийн бүх талууд оролцох ёстой гэж үзэж байна.




График4. Усны менежментэд оролцох нь зүйтэй гэж үнэлэгдсэн талууд

Усыг зүй зохистой ашиглаж хамгаалахад эдгээр талуудын оролцоог үнэлэх асуултад ерөнхийдөө дундаж буюу “дунд зэрэг”, “өндөр” гэсэн хариултууд давамгайл байна.

Хүмүүс эдгээр талуудын алинд нь ч “туйлын итгэлтэй байна” эсвэл “туйлын итгэлгүй байна” гэсэн хариулт өгөөгүй байна.

Дүн шинжилгээ, санал зөвлөмж

Усыг зүй зохистой ашиглан хамгаалахад оролцож буй талуудад иргэд хэр хэмжээнд итгэж байгааг нэгтгэн (“жигнэх” хэмээх математикийн тооцооны арга ашиглан) дараах байдлаар (чухлаас эхлэн чухал бус хүртэл) эрэмбэллээ.

Өндөр оноо авсан оролцогч талуудад иргэд илүү итгэл хүлээлгэж байна гэсэн үг. Үүнээс харахад иргэд аль ойр харьцдаг талуудад (орон нутгийн удирдлага, хөршүүд) илүү өндөр сэтгэгдэлтэй, харин тэр болгон харьцаад байдаггүй талуудад (Засгийн газар, уул уурхайн компани) харьцангуй доогуур сэтгэгдэлтэй байна.



График 5.
Усны менежментэд оролцогч талуудад иргэд хэр итгэж хүлээлгэж буй байдал

‘Усны менежмент’ хэмээх ойлголт нь усыг хэрэгцээндээ нийцүүлэн зүй зохистой ашиглахын тулд усны чанарыг тодорхойлох, эх үүсвэрийг нь хамгаалах, тодорхой ажил төлөвлөж хэрэгжүүлэх, ус түгээх зэргийг хамарна.



Усыг хөдөө аж ахуйд хамгийн ихээр ашиглаж байна.



70%



52%

өдөрт



Хоол унданд



40Л



Угаалга
цэвэрлэгээ



10- 60Л



Хөдөө аж ахуй




500- 3000 Л

График 6. Өмнөговь дахь усны хэрэглээ /литр/

Бүх талд мэдээлэл сайн өгч, оролцоог хангаж, нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлж байж ус хэмээх энэ үнэт баялгаа бид аюулгүй хамгаалж, урт хугацаанд тогтвортой ашиглаж чадна. Монгол орны хувьд ирээдүйд усны баталгааг хангахдаа дараах нийтлэг зорилтыг тавиад байна. Үүнд:

- Чанарыг сайжруулж, хэрэглээг багасгах (эх үүсвэрийг хамгаалах, хяналт тавих, усны үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар)
- Одоогийн хэрэглээ ба ирээдүйн хэрэгцээний тэнцвэрийг хадгалах (усыг эдийн засаг, нийгмийн хувьд дээд зэргийн хэмнэлттэй ашиглана гэсэн үг).

Усны менежментийг сайжруулахын тулд шинжлэх ухааны мэдлэг болоод зохистой технологитой байх шаардлага тулгарч байна. Бодит баримтад тулгуурлаагүй мэдээлэл нь буруу ойлголт төрүүлэх магадлалтай байдаг.



Байгаль дахь усны эргэлт

Усны хүртээмж

Ерөнхий үр дүн

Өмнөговь аймагт хийсэн 2013 оны судалгаагаар ахуйн ба аж ахуйн хэрэгцээний усны хүртээмжид улирлын ялгаа нөлөөтэй эсэхийг тодруулахад оролцогчдын бараг тэн хагас (46%) нь зун хамгийн ихээр, түүний дараагаар хавар нэлээд багасдаг гэж хариулжээ. Энэ нь дулааны улиралд хот суурингийн хүмүүс хөдөө түр суурьших, усны шугам хоолойд засвар хийгддэгтэй холбоотой байж болох юм. Үүнтэй адилаар малчид хавар, зуны улиралд малаа илүү тараан бэлчээдгээс ахуйн хэрэгцээний (ихэвчлэн мал аж ахуйд) усны хүртээмж багасдаг байх магадлалтай. Гэхдээ энэ нь илүү урт хугацааны асуудал бөгөөд үүнийг малын тоо толгой өсч, уул уурхай, үйлдвэрлэл зэрэг бусад үйл ажиллагаа идэвхижиж буй аль алинтай нь холбон тайлбарлаж болно.





График 7.
Усны хүртээмж улирлаас хамаарч хэрхэн өөрчлөгддөг байдал


Үзэл бодол

Улирлын ялгааг эс тооцвол ундны усны хүртээмжийн одоогийн нөхцөл байдлыг оролцогчдын 42 хувь нь “дунд зэрэг” гэж үзэж байна. Гэвч нэлээд хэсэг нь өнгөрсөн таван жилд хүртээмж нь багассан, цаашид улам бүр багасна гэсэн бодолтой байна.

Ирээдүй



Одоо



Өнгөрсөн






График 8. Ундны усны хуртээмж; өнгөрсөн, одоо, ирээдүй

Ирээдүй



Одоо



Өнгөрсөн




График 9. Усны хүртээмж (аж ахуйн хэрэгцээний ус) өнгөрсөн, одоо, ирээдүй

Аж ахуйн хэрэгцээний (ихэвчлэн мал аж ахуй) усны хүртээмжийн өнгөрсөн, одоо, ирээдүйн нөхцөл байдалд хүмүүс ерөнхийдөө ундны усны хүртээмжид өгсөн хариулттай ижил хариулт өгсөн ч ялимгүй сөрөг хандлага илэрсэн.

Дүн шинжилгээ, санал зөвлөмж

Усны хүртээмж, түүний өөрчлөлтийн талаарх иргэдийн бодол үнэн зөв гэж хэлэх боломжгүй юм. Жишээ нь, өмнөх жилүүдийн усны хүртээмжийн талаарх бэлэн мэдээ, тоо баримт маш бага байдаг. Монголд тулгараад буй зарим асуудлын талаар холбогдох тайланд дурдсан байдаг (“Монгол дахь усны менежментийн асуудалд хийсэн шинжилгээ”, 2030 Усны Нөөцийн Бүлэгт зориулан PwC-с гаргасан тайлан). Мөн судалгаанаас харахад сэтгэл зүйн хувьд хүмүүс ихэвчлэн өнгөрсний талаар илүү эерэг бодолтой байдаг ч ирээдүйн талаарх төсөөлөл нь харьцангуй сөрөг байдаг байна. Түүнчлэн сүүлийн үеийн хөгжил дэвшил, цаашдын ирээдүйн талаар сөрөг хандлагатай байдаг хүмүүс санаа бодлоо хуваалцах дургүй байдаг.

Усны хангамж өөрчлөгдөж буйг эс тооцвол усны хэрэгцээ сүүлийн жилүүдэд улам бүр өсч байна. Нэг жишээ нь малын тоо толгой өсөхийн хэрээр усны хэрэгцээ улам бүр ихэсч байна. Малын тоо 2011-2015 онд жилд дунджаар 12 хувиар буюу 33-52 саяар (ҮСХ, 2015) өсчээ. Энэ их малын ундны хэрэгцээнээс гадна мал аж ахуйтай холбоотой дагалдах хэрэгцээ бас дагаад өсч байна. Тухайлбал, малын тэжээл тарих, малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах гэх мэт.

Мэдээж бусад улсын адил хүн амын тоо өсч, үйлдвэрлэл хөгжиж буй нь Монгол улсад усны хэрэгцээ өсөх бас нэг шалтгаан болж байна.

УНДАНД 20.1%

Хүн амын хэрэглээ 17.2%

Хотын үйлчилгээ 2.9%



ҮЙЛДВЭРЛЭЛД 25.2%

Хүнс ба хөнгөн үйлдвэр 1.1%

Хүнд үйлдвэр 0.4%

Барилга 10.4%

Эрчим хүч ба уул 12.9%

уурхай

“2015 онд уул уурхайн салбарт 40 сая метр куб ус ашиглах төлөвтэй байгаа ба энэ тоо 2025 онд 83 болж өсөх тооцоо гарчээ.”

Говийн зарим аймагт (Өмнөговь, Дундговь, Дорноговь) ‘...усан дахь эрдсийн агууламж их байдаг тул газрын доорх усны чанар муу, ихэнх газарт ундны усны стандартаас доогуур үзүүлэлттэй байдаг’ (АХБ, 2014) аж. Энэ нь усны ууршилтын хэмжээ жилд унаж буй хур тунадасны хэмжээнээс илүү байдагтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, ууршилт их явагдаж усанд давс ихээр тунаж үлддэг байна. Иргэдийн дундах дараах яриа үүний илрэл болж байна. Үүнд:

- Угаалгын нунтагны хөөсрөх буюу угаах чанар нь багассан
- Говийн нутагт ихэвчлэн цайндаа давс хийх шаардлагагүй байдаг
- Хүмүүсийн шүдний өвчлөл их

Давсны агууламж ихтэй шилэн аягатай усыг агаарт аажим уриуулахад аяганы дотор талд давс үлдэнэ.


2003 онд говийн аймгуудын усанд хийсэн судалгаагаар (Дэлхийн банк, 2009) 1704 дээжийн 57 хувьд нь хүлцэх хэмжээнээс (цэнгэг усны хувьд 1000мг/л) илүү эрдэс бодис илэрсэн байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙД 54.7%

Мал аж ахуй 24%
Газар тариалан 30.7%



Усны хүртээмж багассан гэж үзсэн иргэдийн хувьд усны хангамж багассандаа бус харин салбар бүрт усны хэрэгцээ ихэссэнтэй холбоотой байж болох юм. Үүнийг говийн усны хэрэгцээ цаашид урт хугацаанд өсөх төлөвтэй байгаагаас харж болно. Жишээ нь, хэрвээ илүү их усны нөөцтэй болбол судалгаанд оролцогчдын



Иймд, Өмнөговь аймгийн ирээдүйн төлөө усаа хэрхэн тогтвортой ашиглах талаар шийдвэр гаргахад бүх талууд оролцож, хамтарч ажиллах нь маш чухал байна.

Жишээ нь, Байгаль орчин, ногоон хөгжил аялал

жуулчлалын яам БОНХАЖЯ)-аас орон нутгийн болон бүсийн хэмжээнд бодлого төлөвлөх замаар ирээдүйд усны менежментийг сайжруулахаар ажиллаж байна.

Улсын хэмжээнд ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн)-ий хэмжээ богино хугацаанд доогуур (<http://www.adb.org/countries/mongolia/economy>) байна. Ялангуяа 2011 оны их өсөлттэй харьцуулахад нэлээд бага байгаа нь ихэнх эрэлт хэрэгцээ буурахад нөлөөлж байна. Үйлдвэрлэл, малын түүхий эд боловсруулах зэрэг баялаг бүтээх салбарт эрэлт хэрэгцээ буурч байна. Гэвч урт хугацаанд манай улсын эдийн засаг өсч, өрхийн болон үйлдвэрлэл дэх усны хэрэгцээ улам нэмэгдэх хандлагатай байна.




График 10.
ДНБ-ий өсөлт;
Монгол Улс, 2011-2016

Усны төлөөх өрсөлдөөн


Ерөнхий үр дүн

Монгол орны хувьд байгаль экологийн эмзэг нөхцөлд усны нөөц ховордох асуудал тодорхой хэмжээнд яригдсаар ирсэн. Ялангуяа, сүүлийн 25 жилийн хугацаанд ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн орны хувьд хүн амын амжиргаа, амьдралын хэвшил өөрчлөгдөж, усны хэрэгцээ өсч ирсэн. Энэ асуудал олон улсын хандивлагч байгууллага, байгаль орчны ТББ-ууд, үндэсний болон дэлхийн хэвлэл мэдээллийн анхаарлыг татах болсон. Тухайлбал:

- Монгол улс усны асуудалтай хурцаар нүүр тулж байна, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн тайлан
- Улаанбаатар хотын усны нөөц дуусч байгаа юу?
- Усны нөөцийн хомсдол Монгол улсын тогтвортой хөгжилд саад болж байна.

Усны нөөцийн асуудал орон нутагт мөн хөндөгдөж байгаагийн нэг илрэл нь 2016 оноос Өмнөговь аймагт уул уурхайн зориулалтаар газрын доорхи ус ашиглахыг хориглох тухай тогтоол (Өмнөговь аймгийн ИТХ-ын 2013 оны 7 сарын 2-ны 3/9 тогтоол) гарсан явдал юм. Гэвч энэхүү шийдвэрийг Засгийн газраас хүчингүй болгосон нь усны талаарх шийдвэр гаргалт ИТХ-ийн эрх мэдлээс давсан асуудал болохыг харуулж байна.

Үзэл бодол







График 11.

Устай холбоотой зөрчил маргааны нөхцөл байдал (одоо, өнгөрсөн, ирээдүй)

Судалгаагаар орон нутагт устай холбоотой зөрчил маргааны тухай тодруулахад хүмүүсийн санаа бодол харилцан адилгүй байв. Тэд “маш муу”-аас “маш сайн” гэсэн таван үзүүлэлтээр үнэлгээ өгсөн ба 31% нь “муу” гэсэн байр суурьтай байв. Энэ нь судалгаанд оролцогчдын бараг гуравны нэг нь хүндрэлтэй асуудал хэтэрхий их байна гэж үзэж буйг харуулж байгаа юм. Мөн 48% нь өнгөрсөн таван жилд зөрчлийн асуудал дордсон, үүнтэй ижил хувь нь ирэх таван жилд улам дордоно гэж үзсэн.

Устай холбоотой зөрчил маргааныг хэн хамгийн сайн шийдвэрлэж чадах вэ гэж асуухад оролцогчид мөн л орон нутгийн (сум, аймгийн) удирдлага, хөрш саахалт, Засгийн газрыг нэрлэж байв.



График 12.
Зөрчил маргааныг зохицуулах
боломжтой гэж үзсэн талууд

Дүн шинжилгээ, санал зөвлөмж

Судалгааны үр дүнгээс харахад өөрсдийн оролцоог чухалчилж үзэхгүй байх тал оролцогчдын дунд ажиглагдсан. Өмнөговьд л гэхэд зөрчлийг арилгахад өөрсдөө оролцох биш бусдыг зохицуулна гэж үзэх хандлагатай байна. Сүүлд гарсан эрх зүйн зохицуулалтаар олон талыг хамарсан Сав газрын зөвлөлүүд байгуулснаарэнэ нөхцөл байдлыг сайжруулахад дөхөм болох юм.

Малчин өрхийн 42% нь, нийт өрхийн 63% нь хэрвээ усны хүртээмж ихэсвэл мал аж ахуй, газар тариаланд ашиглана гэжээ. Малын тоо хэдийн өсч (одоо 52 сая болох хүртэл) эхэлсэн ч тухайн үед малчид дахин малын тоогоо нэмэгдүүлнэ гэсэн байх юм.

Усны талаархи МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Ерөнхий үр дүн

Монгол хийгээд дэлхийн хэмжээнд усны асуудал шинэ биш ч энэ нөөцийн эрэлт хэрэгцээ улам бүр ихэсч байгаа энэ үед бүх тал бүтээлчээр сэтгэж, хамтран ярилцаж цаашид хэрхэн усаа зүй зохистой ашиглаж, хамгаалах вэ гэдгийг бодох шаардлага тулгарч байна. Ялангуяа, оролцогч талуудад:


- Гадаргын болон газрын доорхи ус, түүний менежментийн талаарх тоо баримт бүхий үнэн бодит мэдээлэл авах;
- Усны ашиглалт, хамгаалалтын талаархи өөрчлөгдөн шинэчлэгдэж буй бусдын хүсэлт шаардлагыг хүндэтгэх;
- Аливаа шийдвэр гаргахдаа баттай мэдээлэлд үндэслэх хэрэгцээ шаардлага их байна.

‘Тоо баримт’, ‘мэдээ мэдээлэл’, ‘шинэ мэдлэг’ бол усны асуудлаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд маш чухал юм.

Мэдээлэл бол яг л устай адил тул урсаж байх хэрэгтэй.

Усны талаарх мэдээлэл, тоо баримт олж авах нь тулгамдаж буй асуудал, зөрчил маргааныг сайн ойлгож авахад тустай. Мэдлэг бол шийдэл олох арга хэрэгслийг зааж өгдөг. Асуудлыг зөв ойлгоогүй бол зөв шийдэлд хүрэхэд хэцүү юм.

Үзэл бодол





Үүнтэй бараг ижил хувь нь усны нөөц тэр дундаа усны менежментийн талаарх мэдлэг мэдээлэл хангалттай авч чаддаггүй гэсэн байна. Цөөн хэдэн оролцогч усны талаарх хууль журмын нэр дурдсан.

Иргэдийн усны талаар мэдээлэл авдаг хамгийн түгээмэл сувгуудыг жагсаалаа. Үүнд:

- Телевиз,
- Хурал (орон нутгийн удирдлагаас зохион байгуулдаг)
- Уулзалт цуглаан (иргэдийн нөхөрлөл, бүлгээс зохион байгуулдаг)

Харин хамгийн түгээмэл мэдээллийн эх сурвалжийн 4-рт ам дамжсан яриа орсон байна. Түүнчлэн, ихэнх (92%) оролцогч илүү мэдээлэл авах хүсэлтэй, болж өгвөл телевиз, уулзалт, радиогоор дамжуулбал тохиромжтой гэж үзсэн.



Дүн шинжилгээ, санал зөвлөмж

Мэдлэг мэдээлэл бол мөн л устай ижил. Энэ хоёрт ижил төстэй талууд олон бий. Жишээ нь:

- Ховор - заримдаа зарим талаар маш ховор
- Үнэтэй – үргэлж хүсэн хүлээж, хүндэтгэлтэй ханддаг
- Аль алинд нь чанарын асуудал байнга яригддаг.

2013 оны судалгаагаар Өмнөговийн иргэдийн устай холбоотой тоо баримт, мэдээллийг цуглуулсан билээ. Энэ эмхэтгэл (уулзалт хэлэлцүүлгийн хамт) ч судалгааны гол үр дүнг танилцуулахын зэрэгцээ хүмүүсийн мэдлэг, мэдээлэл олж авах гэсэн хэрэгцээнд нэмэр болох зорилготой. Дээрх зорилтын хүрээнд ОУСК-иас Өмнөговь аймагт дараах үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- 2013 оны “Усны талаарх иргэдийн мэдлэг хандлагыг тодорхойлох суурь судалгаа”,
- 2014 оны “Газрын доорхи усны менежмент” сэдэвт сургалт,
- 2015 оны “Судалгааны үр дүнг танилцуулах уулзалт хэлэлцүүлэг”
- 2015 оны усны мониторингийн сургалт ба
- 2015 Мэдээлэл харилцааг сайжруулах стратеги

Ирээдүй

Ерөнхий үр дүн

Энэхүү эмхэтгэл, уулзалт хэлэлцүүлэг болон дээр дурдсан бусад арга хэмжээ нь дараах зорилготой. Тодруулбал

- Усны талаарх мэдлэгийг дээшлүүлэх
- харилцан яриа эхлүүлэх үүд хаалгыг нээх
- хамтаар шийдвэр гаргах явдлыг дэмжихэд зориулсан.

НҮБХХ, Дэлхийн банк, 2030 Усны нөөцийн бүлэг, Монголын (болон олон улсын) их дээд сургуулиуд, уул уурхайн компаниуд гээд бусад олон байгууллага энэ талаар хэдийнэ арга хэмжээ авч, төрөл бүрийн ажил хийж байна. Гэсэн хэдий ч оролцогчид усны асуудал дахь оролцоо хангалтгүй байна гэж үзсэн. Орон нутгийн иргэдийг усны менежментэд илүү идэвхитэй оролцуулахад илүү мэдээлэл шаардлагатай байгааг судалгаанд оролцогчид онцолсон юм.

Үзэл бодол

2013 оны судалгаанд оролцогчид цаашид ус тойрсон асуудлыг багасгахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хэрэгжих хэрэгжихгүй гэхээсээ үл хамааран иргэд ямартай ч усны асуудалд оролцох өндөр хүсэл эрмэлзэлтэй байгаа нь харагдлаа.



График 14.
Цаашид хэрхэх талаар иргэдийн өгсөн санал зөвлөмж

Дүн шинжилгээ, санал зөвлөмж

Мэдээлэл солилцож, оролцоог дээшлүүлэх нэг арга нь интернэт байж болох юм. Дэлхий даяар олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, блог, онлайн сургалт ашиглан мэдээллийг цаг үетэй нь зэрэгцэн хурдан шуурхай олж авах олон арга хэрэгсэл хөгжиж байна. Хэдийгээр Өмнөговь аймагт интернэтийн сүлжээ тийм өргөн нэвтрээгүй ч сүлжээний цар хүрээ тэлж, ухаалаг утасны хэрэглээ нэмэгдэж байна. Энэ чиглэлээр мэдээлэл солилцох илүү нарийвчилсан арга хэлбэрийг Мэдээлэл харилцааг сайжруулах стратеги төслөөс одоо боловсруулж байгаа юм.

Эх сурвалж

Нэмэлт мэдээлэл авах материалууд

<p>АХБ, 2014. “Товийн хэрэгцээ; Монголын Ус-Эрчим хүч-Уул уурхайн уялдаа холбоо”. 68 хуудас, англи. http://www.zaragoza.es/contenidos/medioambiente/onu/1419-eng-ed2014_Demand_in_the_Desert.pdf</p>
<p>Ж.Деттони, 2014. “Улаанбаатар хотын усны нөөц шавхагдаж байгаа юу?” англи http://thediplomat.com/2014/05/is-ulaanbataar-running-out-of-water/</p>
<p>ЗГ, 2012. Усны тухай хууль. 5 сарын 17. 17 хуудас. Монгол, англи</p>
<p>Хараат бус судалгааны хүрээлэн, 2013. “Усны талаарх иргэдийн мэдлэг хандлагыг тодорхойлох судалгаа”. 71 хуудас. Монгол, англи</p>
<p>Жадамба, 2012. “Монголын геологи ба гүний ус, Гидрологи”. 548 хуудас. Монгол</p>
<p>Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Дэлхийн эдийн засгийн чуулга, Давос (2015 он), Швейцарь, монгол, англи</p>
<p>“Sustainability East Asia” ХХК, “Groundwater Solutions” ХХК, 2014. Мэдээллийн хуудас; “Уул уурхай, усны менежмент”. 16 хуудас. Монгол.</p>
<p>“Sustainability East Asia” ХХК, “Groundwater Solutions” ХХК, 2014. “Монголын уул уурхай, усны менежмент” сургалтын материал. 93 слайд, монгол, англи</p>
<p>Т.Тюниссен, 2014. “Монголын тогтвортой хөгжилд саад болж буй усны хомсдол”, англи http://asiafoundation.org/in-asia/2014/09/17/water-scarcity-a-threat-to-mongolias-sustainable-development/</p>
<p>НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, 2011. “Монголын усны нөөцийн хомсдол нүүрлэх ойрхон байна” тайлан, англи. http://www.unep.org/Documents.Multilingual/Default.Print.asp?DocumentID=664&ArticleID=8668&l=en</p>
<p>Дэлхийн банк, 2009. “Товийн бүсийн гүний усны судалгаа”. 64 хуудас, англи. http://siteresources.worldbank.org/INTMONGOLIA/Resources/Southern_mongolia_groundwater_assessment_eng.pdf</p>

Илүү ихийг мэдэхийг хүсвэл

http://www.mne.mn/	Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
www.altai.gobiwater.mn	Алтайн Өвөрговийн Сав Газрын Захиргаа; мөн Facebook хуудас.
www.galba.gobiwater.mn	Галба-Өөш Долоодын Сав Газрын Захиргаа: мөн Facebook хуудас;
www.gobi.gobiwater.mn	Умард Говийн Гүвээт Халхын Дундад Талын Сав Газрын Захиргаа
www.riverbasin.mn/ongi-gol	Онги Голын Сав Газрын Захиргаа
http://eic.mn/	Байгаль орчны мэдээллийн бааз, Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
http://www.iic.mn	Ус цаг уур, орчны шинжилгээний газар
https://www.facebook.com/mne.mn	Байгаль орчин ногоон хөгжлийн яамны Facebook хуудас
watersolutions.mn	“Ground Water Solutions” ХХК
www.om.inspection.gov.mn	Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар

Дараах газруудад хандах боломжтой

Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэсний Гудамж 5/2, Улаанбаатар хот 2106460. Утас: 51-2619661 51-266171
Ус цаг уур, орчны шинжилгээний газар	Ус цаг уур эрдэм шинжилгээний хүрээлэнгийн байр, Жуулчны гудамж 5, Улаанбаатар хот 15160. Утас: 11-329968
Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн /Ус, байгаль орчин/	Ус цаг уур эрдэм шинжилгээний хүрээлэнгийн байр, Жуулчны гудамж 5, Улаанбаатар хот 15160. Утас: 11-329968
Алтайн Өвөрговийн сав газрын захиргаа	Төрийн банкны байр, 4-р давхар, Даланзадгад хот, Өмнөговь аймаг. Утас: 7053-4080, 7053-4081
Галба-Өөш Долоодын сав газрын захиргаа	“Шанти” төвийн байр, 2-р давхар, Сайншанд хот, Дорноговь аймаг. Утас: 7052-3682
Онги голын сав газрын захиргаа	Арвайхээр хот, Өвөрхангай аймаг. Утас: 9818-0033, 9532-4324
Умард Говийн Гүвээт Халхын Дундад Талын Сав Газрын Захиргаа	12-р байр, 4-р орц, 58 тоот. Сүмбэр сум, 3-р баг, Говьсүмбэр аймаг. Утас: 70543598
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Засгийн газрын VII байр, Барилгачдын талбай 13, Улаанбаатар, 15170
Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар	Даланзадгад хот, Өмнөговь аймаг Утас: 7053-2624

Монголын уул уурхайн үндэсний ассоциаци	Скай Плаза, 4-р давхар, 6 тоот, Олимпийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар Утас: 11-314877
“Sustainability East Asia” ХХК	Сан бизнес төв, 501, Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар Утас: 7011 4921
“Ground Water Solutions” ХХК	Сан бизнес төв, 701, Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар Утас: 7011-3921
“Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо” ТББ	Ногоон нуур, 7а байр, 102 тоот, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот. Утас:
“Тогтвортой бичил уурхай” төсөл, Мэдлэгийн төв	Швейцарийн хөгжлийн агентлаг, Скай Плаза, Олимпийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот. Утас: 11 328848

Огноо 2015 оны 9 дүгээр сар

ОУСК **Олон Улсын Санхүүгийн Корпораци**

MCS Плаза, 4-р давхар

Сөүлийн гудамж 4

Улаанбаатар 210644

Монгол Улс

Утас: +976 7007 8280

Факс: +976 7007 8285

<http://www.ifc.org>

IRIM **Хараат Бүс Судалгааны Хүрээлэн**

45-р байр, 30 тоот,

8-р хороо, Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар 14201,

Монгол Улс

Утас/Факс: +976-70117101,

Имэйл: contact@irim.mn

<http://www.irim.mn>